

Эхэд тулгуурлан багц даалгаврууд гүйцэтгэх тул доош гүйлгэн бүх даалгаврыг ажиллана уу!

Монголын нууц товчооны тухайд

Монголчууд дэлхийг тодорхойлон байсан хэдэн зууны нэгхэн үеийн их хөлгөн судар Монголын нууц товчоон олон газар орны эрдэмт мэргэдийн цэц ухааныг сорьсон шинжилгээ судалгааны эргэлтэд орж, олон зууныг элээсэн ч монголчууд бидний хувьд улам бүр чухал бөгөөд сонирхолтой сэдэв болсоор байна.

Бид үндэсний ухамсар, мэдрэмжээ сэргээж, унаган соёлын дархлаа юугаа бэхжүүлж бататгах, зан үйлийн боловсролыг чухалчилж, Монгол иргэн хүнийг төлөвшүүлж бүтээхэд энэхүү суут бүтээлийн ач холбогдол үлэмж их хэмээн би боддог.

Яагаад гэвэл, Монголын нууц товчоон бол бидний хувьд монголчуудын амьдралын бүхий л талыг эрин цагтаа цомносон аугаа гайхамшигтай гэхээс өөрөөр хэмжишгүй суут бүтээл юм. Би Монголын нууц товчооныг хэрхэн үздэг тухай санаагаа дараах байдлаар тоочин илэрхийлье.

1. Монголын нууц товчоон бол алтан ургийнхны өндөр өвөг дээдсээс үр хойчдоо гэрээсэлж захиасалсан удам судрын ургийн бичиг мөн.
2. Монголын нууц товчоон бол гал голомтоо бадраан, амар жаргалантай аж төрөх ураг барилдлага, худ худгуйн ёсноос эхшүүлээд монголчуудын аливаа ёс заншил, бэлгэдэл, эрхэмлэлийн түүхэн тайлбар толь мөн.
3. Монголын нууц товчоон бол хаан төрөө хэрхэн урлан бүтээх, улс гэрээ хэрхэн мандуулах, хүн ардаа улмаар, даян дэлхийг хэрхэн айх аюулгүй, амар амгалан, тогтвортой оршин тогтноулах хийгээд улс төрийн ёс суртахууны талаарх бодлогын тунхаг мөн.
4. Монголын нууц товчоон бол монголчуудын домог зүйн сэтгэлгээний шид эрдмийг чандад нь хүргэн ширээж тэрлэсэн үнэмлэхүй дээд тэнгэрч үзлийн номлол төдийгүй бас биелэл юм.
5. Монголын нууц товчоон бол унаган нутгаа биширч дээдлэх, уул ус, тэнгэр хангайдаа даатгал залбирал одуулах, илбэ дом, задын ёс, зайран бөөгийн зүхэл, тайлгын дэлгээстэй ном мөн.
6. Монголын нууц товчоон сурган хүмүүжүүлэх сургаал үзэл, андын ёс, андгай тангараг, нэр төр, хариуцлага, шийтгэлийн жишиг үзүүлэн, хууль ёсны амьд эрх зүй, биет ёс суртахуун мөн.
7. Монголын нууц товчоон бол аж ахуй, эдийн засаг, аргалчин, усчин, хорчин, унагачин, саальчин, нутагчин, замчин, улаач гээд монголчуудын уламжлалт ажил мэргэжил, хөдөлмөр зохион байгуулалтын нэвтэрхий толь мөн.
8. Монголын нууц товчоон бол хэл зохиол, түүх бичлэгийн үндэсний сонгодог арга зүй бүхий бийр нь хурц, билиг оюун төгс бичгийн мэргэдийн туурвисан ижил нь үгүй номон хөшөө мөн билээ.
9. Монголын нууц товчоон бол хэн нэгэн бичиглэгчийн санаан зоргын бүтээл биш харин алтан ургийн Тэнгэр язгуурт хааны зарлигаар бичигдсэн Монголын Тэнгэр язгууртны төрийн албан ёсны түүх юм хэмээн үзэж байна.

Нэгэн цагт манай эрдэмтэн судлаачдын судалгаа, бүтээл Монголын нууц товчооны хэл зохиол, түүхийн дурсгал, эх сурвалж болох тал руу нь илүүтэй хандсан гэлтэй байдаг. Харин эдүгээ тэдний судалгаа олон чиглэлд эрчимжиж байгаа нь нэн сайшаалтай.

Ж.Отгонбаяр *“Домог зүйн философи судалгаа”* 2024.

хэсэглэн авав, 180-182

Монгол хэлний даалгаврууд

1. Зохиогч бүх илэрхийллээ “мөн” гэж дуусгасан нь ямар учиртай вэ?
 - A. Баримт болгон баталж нотолсон.
 - B. Өөрийн үзэл бодлыг тулгасан.
 - C. МНТ-д хандаж буй үнэлэмжээ тодотгосон.
 - D. МНТ-ны тухай болоод агуулгын задлал хийснээ харуулсан.

2. Нийтлэлийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
 - A. Монголын нууц товчоон бол бидний хувьд монголчуудын амьдралын бүхий л талыг эрин цагтаа хураангуйлан цомносон аугаа гайхамшигтай гэхээс өөрөөр хэмжишгүй суут бүтээл юм
 - B. Харин эдүгээ тэдний судалгаа олон чиглэлд эрчимжиж байгаа нь нэн сайшаалтай.
 - C. Бид үндэсний ухамсар, мэдрэмжээ сэргээж, унаган соёлын дархлаа юугаа бэхжүүлж бататгах, зан үйлийн боловсролыг чухалчилж, Монгол иргэн хүнийг төлөвшүүлж бүтээхэд энэхүү суут бүтээлийн ач холбогдол үлэмж их хэмээн би боддог.
 - D. Монголын нууц товчоон бол хэн нэгэн бичиглэгчийн санаан зоргын бүтээл биш харин алтан ургийн Тэнгэр язгуурт хааны зарлигаар бичигдсэн Монголын Тэнгэр язгууртны төрийн албан ёсны түүх юм хэмээн үзэж байна
3. Зохиогчийн тоочин нэрлэж буй 9 санаанд ямар өнгө аяс давамгайлсан бэ?
 - A. Монголын нууц товчооны учир шалтгааныг эрж хайн мухардсан тул эргэлзэж тээнэгэлзсэн өнгө аяс
 - B. Монголын нууц товчооны тухайд санал бодлоо нэгтгэн баталж нотолсон өнгө аяс
 - C. Монголын нууц товчооны тухай шинэ мэдээлэлдээ тулгуурлан бичсэн тул цэгнэж үнэлсэн өнгө аяс
 - D. Монголын нууц товчооныг түүхэн гайхамшигт судар хэмээн бахархаж бардамнасан өнгө
4. "... монголчуудын амьдралын бүхий л талыг эрин цагтаа цомносон" хэмээсний учир юу вэ?
 - A. Монголчуудын амьдралын бүхий л талыг товчлон хураангуйлж бичсэн гэх санаа
 - B. Монголчуудын амьдралын бүхий л талыг нэг бүрчлэн дэлгэрэнгүй бичсэн гэх санаа
 - C. Монголчуудын амьдралын бүхий л талыг задлан тайлбарлаж бичсэн гэх санаа
 - D. Монголчуудын амьдралын бүхий л талыг ёгтлон өгөөдөж бичсэн гэх санаа
5. Аль өгүүлбэрийг ердийн найруулгаар бичсэн бэ?
 - A. Монголын нууц товчоон бол алтан ургийнхны өндөр өвөг дээдсээс үр хойчдоо гэрээсэлж захиасалсан удам судрын ургийн бичиг мөн.
 - B. Монголын нууц товчоон бол аж ахуй, эдийн засаг, аргалчин, усчин, хорчин, унагачин, саальчин, нутагчин, замчин, улаач гээд монголчуудын уламжлалт ажил мэргэжил, хөдөлмөр зохион байгуулалтын нэвтэрхий толь мөн.
 - C. Монголын нууц товчоон бол монголчуудын домог зүйн сэтгэлгээний шид эрдмийг чандад нь хүргэн ширээж тэрлэсэн үнэмлэхүй дээд тэнгэрч үзлийн номлол төдийгүй бас биелэл юм.
 - D. Монголын нууц товчоон бол хэл зохиол, түүх бичлэгийн үндэсний сонгодог арга зүй бүхий бийр нь хурц, билиг оюун төгс бичгийн мэргэдийн туурвисан ижил нь үгүй номон хөшөө мөн билээ.
6. "Билиг оюун төгс бичгийн мэргэдийн туурвисан ижил нь үгүй номон хөшөө мөн билээ" хэмээх дүрслэл нь юм.
 - A. Амьдчилал
 - B. Адилтгал
 - C. Хүншүүлэл
 - D. Хэтрүүлэл
7. "гэрээсэлж захиасалсан" хэмээх холбоо үг нь үгийн сангийн онцлогоороо юм. Цэгийн оронд тохирохыг сонгоорой.
 - A. Хэлбэрээрээ адил боловч утгаараа ялгаатай учир ижил үг
 - B. Утгаараа харилцан эсрэгцсэн тул эсрэг үг
 - C. Нэг ойлголт, юмсыг өөрөөр нэрлэж буй тул ойролцоо үг
 - D. Хэлбэр, утга, дуудлагын аль нэг шинжээрээ төстэй учир төсөө үг

8. Дээрх нийтлэл сэдвийн хувьд аль ангилалд хамаарах вэ?
- A. Ухаарал бодролын тухай
 - B. Шинжлэх ухаан, судалгааны тухай
 - C. Нийгэм улс төрийн тухай
 - D. Урлаг соёлын тухай
9. "... аугаа гайхамшигтай гэхээс өөрөөр хэмжишгүй суут бүтээл юм" гэх өгүүлбэрт буй "гэхээс" холбоос өгүүлбэрт ямар утга илэрхийлж байна байна вэ?
- A. Эш татах утга
 - B. Баймж утга
 - C. Болзлын утга
 - D. Шалтгааны утга
10. Нийтлэлийг ямар эх сурвалжид тулгуурлан бичсэн бэ?
- A. Хэн нэгнээс сонссон хууч ярианд тулгуурласан
 - B. Түүхэн сурвалж бичигт тулгуурласан
 - C. Түүхэн домогт тулгуурлан бичсэн
 - D. Аман мэдээнд тулгуурлан бичсэн
11. Найм дахь санаанд буй "номон хөшөө" хэмээх дүрслэлийг солин найруулахад аль нь тохиромжтой вэ?
- A. мөнхөд орших бүтээл
 - B. сүрлэг сайхан бүтээл
 - C. түүхэн сургамжит бүтээл
 - D. сэтгэлд хоногших бүтээл
12. "Жинхэнэ аз жаргалыг хаана эдэлснээ мэдэж байна" гэсэн өгүүлбэрийг шалтгааны утгаар дэлгэрүүлбэл аль өгүүлбэр тохиромжтой вэ?
- A. Жигүүрээ дэлгэсэн бага балчир насандаа
 - B. Хайртай ижийнхээ дэргэд л
 - C. Эдийн сайныг эдлүүлж өсгөсөн болохоор
 - D. Ижийнхээ ач буяныг хариулах сан

Үндэсний бичгийн даалгаврууд

Ажиллах эх

1. Мал маллах арга ухааны тухай
 2. Малчин хүний хөдөлмөрийн тухай
 3. Малын ашиг шимийн тухай
 4. Малчин хүний баяр жаргалын тухай
 5. Малчин хүний хөдөлмөрийн тухай
 6. Малчин хүний хөдөлмөрийн тухай
 7. Малчин хүний хөдөлмөрийн тухай
 8. Малчин хүний хөдөлмөрийн тухай
 9. Малчин хүний хөдөлмөрийн тухай
 10. Малчин хүний хөдөлмөрийн тухай
 11. Малчин хүний хөдөлмөрийн тухай
 12. Малчин хүний хөдөлмөрийн тухай

13. Эхэд юуны тухай өгүүлж байна вэ?

- A. Мал маллах арга ухааны тухай
- B. Малчин хүний хөдөлмөрийн тухай
- C. Малын ашиг шимийн тухай
- D. Малчин хүний баяр жаргалын тухай

14. Аль үгсийг алдаатай бичсэн байна вэ?

- A. Мал
- B. Малчин
- C. Малын
- D. Малчид

15. « ᠮᠠᠯ ᠮᠠᠯᠠᠭ ᠠᠷᠭᠠ ᠤ᠋ᠯᠠᠭ » хэмээх үгсэд буй « ᠮᠠᠯ - ᠮᠠᠯᠠᠭ » бүтээврийн утгыг зөв тайлбарлаарай.

- A. Бусдаар үйлдүүлэх хэвийн “-лга4” дагавар
- B. Нэрээс нэр үг бүтээх “-лга4” дагавар
- C. Үйлээс тэмдэг нэр бүтээх “-лга4” нөхцөл
- D. Үйлээс нэр үг бүтээх “-лга4” дагавар

16. “Атганд багтаад авдарт багтахгүй” хэмээх оньсогыг зөв бичсэн нь аль вэ?

- A. Атганд багтаад авдарт багтахгүй
- B. Атганд багтаад авдарт багтахгүй
- C. Атганд багтаад авдарт багтахгүй
- D. Атганд багтаад авдарт багтахгүй

17. “Мал өсгөө гэвэл

Мах идье гэвэл” сургаалыг гүйцээж бичээрэй.

- A. Мал өсгөө гэвэл
- B. Мал өсгөө гэвэл
- C. Мал өсгөө гэвэл
- D. Мал өсгөө гэвэл

Уран зохиолын даалгаврууд

18. С.Дашдооровын “Бууж мордох хорвоо” өгүүллэгийн “Манийг бодох нь оо ёстой малчин хүн байсан даа. Биднийг одоо дарга нар тэргүүний малчин, мэнд сүрэгтэн энэ тэр гээд л магтаад байна. Ангаагийн дэргэд бид юу байх вэ дээ. Энэ дарга нар бага хүүхэд, өндөр настан хоёрын ажлыг үзэх биш” гэсэн хэсэгт юуны тухай хам сэдвийг хөндөн өгүүлж байна вэ?
 - A. Шашны тухай хам сэдэв
 - B. Нийгмийн тухай хам сэдэв
 - C. Гүн ухааны тухай хам сэдэв
 - D. Намтрын тухай хам сэдэв
19. С.Дашдооровын “Бууж мордох хорвоо” өгүүллэгт, “Энэ хойд дээгүүр гараад ирсэн чинь, далай цагаан хонь налайн харагдахаар нь баярлаж л байлаа. Тэгээд ажсан чинь чи явж харагдана гэж өгүүлэн унааныхаа толгойг өмнө зүг залав” гэсэн нь юм. Цэгийн оронд тохирохыг сонгоорой.
 - A. Харилцан яриа
 - B. Дотоод яриа
 - C. Ганцаарчилсан яриа
 - D. Үглэл яриа
20. С.Дашдооровын “Бууж мордох хорвоо” өгүүллэгт, “Яриа юу байх вэ, төрийн нуруу төвшин хүн явж дээ гэснээ “Энэ малд ч мөн нүдтэй сэн...” гэж бахархангуй дуу алдан түрэв” хэмээсэн Төгөө өвгөний ярианаас түүний ямар чанар илэрч байна вэ?
 - A. Амьдралын нарийн ухаан
 - B. Нуруутай төлөв төвшин чанар
 - C. Хар буруу санаагүй, сайхан сэтгэл
 - D. Бусдыг урамшуулж чаддаг халуун сэтгэл
21. С.Дашдооровын “Бууж мордох хорвоо” өгүүллэгт Төгөө өвгөний нэгэн үйлийг, “Самбааг бөрт буттай талын хэвгийд шоволзон торойсоор бараа тасартал нь өөрийгөө саатуулан харж байснаа, нугалж суусан өвдөгний ойр гарт өртсөн жижиг жижиг чулууг хэд гурваар нь түүн нойтон алган дотроо өнхрүүлэн эрх мэт нэг нэгээр имрэн сэлгэснээ, ганц ганцаар нь эрхий хуруун дээрээ гарган нясалж саатав” гэж дүрсэлсэн байгаагаас түүний сэтгэл санааны байдлыг тодорхойлоорой.
 - A. Хийх юм, хэлэх үгээ олж ядан сандарсан байдал
 - B. Ямар нэгэн зүйлийг гүнзгий эргэцүүлэн бодлогоширсон байдал
 - C. Хүний амьдралын жам ёсыг тунгаан гуньсхийсэн байдал
 - D. Хэцүү мэдээ дуулсан тул цочирдож балмагдсан байдал
22. С.Дашдооровын “Бууж мордох хорвоо” өгүүллэг дэх, “Мориныхоо биеийн чилээг нь гарган хэдэн алхам хөтлөн явснаа мордон хоёр тийшээ холдон одсон хониныхоо хойноос **товор товор** алхуулжээ” гэсэн өгүүлбэрийн тодруулсан үгийг солин найруулахад аль нь тохиромжтой вэ?
 - A. түргэхэн
 - B. удаанаар
 - C. залхуутайяа
 - D. яаравчлан